



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 21 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот


Нийслэлийн өмчид 5 барилга байгууламж
бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн Багануур, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт тус тус баригдаж ашиглалтад орсон нийт 8,476,843,946 (найман тэрбум дөрвөн зуун далан зургаан сая найман зуун дөчин гурван мянга есөн зуун дөчин зургаа) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан 5 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн
72 дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Барилга, байгууламжийн цэвэр өртөг /төгрөгөөр/	Нийт талбай /м.кв/	Нэгжийн талбайн үнэ /м.кв/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	317 дугаар цэцэрлэгийн барилга	НД-ийн 3 дугаар хороо	2023	1,050,641,201	858,092,714	975,2	879,914.59	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
2	34 дүгээр цэцэрлэгийн барилга	БГД-ийн 20 дугаар хороо	2023	2,715,877,961	2,430,188,237	2736	888,226.69	
3	294 дүгээр цэцэрлэгийн барилга	СХД-ийн 10 дугаар хороо	2021	1,731,172,882	1,164,353,436	1081	1,077,107	
4	Толгойт хөгжлийн төвийн барилга	СХД-ийн 4 дүгээр хороо	2023	1,683,351,902	1,326,945,490	837	1,585,359	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
5	23 дугаар хорооны Иргэдэд үйлчлэх байр	ХУД-ийн 23 дугаар хороо	2022	1,295,800,000	1,295,800,000	248	5,225,000	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
Нийт бүртгэх барилга байгууламжийн дүн				8,476,843,946	7,075,379,877			